

# Монголын татаасны бодлого

Салбаруудын татаасны бодлого үр ашигтай хэрэгжиж байна уу?

Б.Эрдэнэбат  
12/22/2025

# Агуулга

**01** МОНГОЛ ДАХЬ ТАТААСНЫ НӨХЦӨЛ  
БАЙДАЛ


**02** ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР ДАХЬ ТАТААС

**03** ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР ДАХЬ ТАТААС

**04** НИЙТИЙН ТЭЭВРИЙН САЛБАР  
ДАХЬ ТАТААС


**05** АНХААРАХ АСУУДЛУУД БА  
БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

**06** ХЭРЭГТЭЙ ХОЛБООСУУД



# 1. Монгол дахь татаасны нөхцөл байдал

## Нийт татаасны 80% гаруй нь 3 салбарт зарцуулагддаг



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2024 онд төсвөөс олгосон нийт татаасны 83% нь ХАА, эрчим хүч болон нийтийн тээврийн салбаруудад олгогджээ. Дээрх салбаруудад олгосон татаасны дүн 2019 онд нийт татаасны 45%-ийг эзэлж байсан бол тус дүн жил бүр өссөөр. Тэгвэл тус салбаруудад олгогдож буй татаас хэрхэн хэрэгжиж буй, зорилгоо гүйцэлдүүлж буй эсэх талаар дараагийн хэсгүүдэд тодруулъя.

Нийгмийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх, тэгш бус байдлыг бууруулж, хүртээмж, бүтээмжийг өсгөхийн тулд аливаа улс орон татаасны бодлогыг хэрэгжүүлдэг.

Монголын хувьд дараах зорилгуудын хүрээнд салбаруудад татаас олгож байна:

- Нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд нийтийн тээврийн алдагдлын татаас;
- Утааг бууруулах, зорилтот бүлгийг дэмжих үүднээс шөнийн тарифын хөнгөлөлт, нүүрсний татаас;
- Өрх, ААН-үүдийн хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжих үүднээс эрчим хүч, дулааны татаас;
- ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, эрэлтийг хангах үүднээс Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих татаас зэргийг олгодог аж.

## Татаасны зардал жилд дунджаар 26% өсдөг:

2008 онд төсвөөс олгосон нийт татаасны хэмжээ 73 тэрбум байсан бол үүнээс хойш жилд **дунджаар 26%-аар** өссөөр 2024 оны эцэст 955 тэрбумд хүрчээ.

- Татаасны дундаж өсөлт ихээхэн өндөр байгаа хэдий ч хүртээмж, бүтээмж, зорилгын биелэлт тус түвшинд хангагдаж байгаа эсэх нь эргэлзээтэй.

## Татаасны бодлогод улс төрийн амлалт, популизм өндөр нөлөөтэй байж болзошгүй:

2009–2024 онуудын хооронд татаасны зардал сонгуулийн жилүүдэд дунджаар **55%-аар** өссөн бол сонгуулийн бус жилүүдэд **17%-аар** өсжээ.

- Дээрх дүнгээс харахад татаас нь тогтвортой бодлогоос гэхээс илүүтэй улс төрийн гэнэтийн шийдвэрээс хамаардаг байж болзошгүй дүр зурагтай байна. Эсвэл салбарууд сонгуулийн жилүүдэд л түлхүү илүү их хэмжээний татаас авах хүнд цохилтод ордог нь гэнэтийн тохиолдол уу?



Татаасны бодлогын үр дүнг тайлагнаж, үнэлдэггүйгээс татаасны хэрэгжилтийн хяналт алдагдаж, зорилгодоо хүрч буй эсэхийг дүгнэхэд бэрх аж.

## 2. Хөдөө аж ахуйн салбар дахь татаас

### ХАА-н татаас ба бүтээмжийн өсөлтийн чиг хандлага эсрэг буй

Татаас, бүтээмжийн өсөлтийн он тус бүрийн дүнг 3 жилийн дунджаар үзүүлэв.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, ХХААХҮЯ

Тайлбар: Богино хугацааны хэлбэлзлийг арилган, урт хугацааны хандлагыг харуулах үүднээс татаас болон бүтээмжийн өсөлтийг 3 жил (тухайн жил болон түүнээс өмнөх 2 жил) -ийн дунджаар тооцов. Бүтээмж гэдэг нь тухайн салбарт ажиллаж буй нэг ажилчинд ногдох үйлдвэрлэлийн хэмжээг бодит дүнгээр илэрхийлсэн үзүүлэлт юм.

Монголын хөдөө аж ахуйн салбар нь байгалийн гамшиг, цаг уураас өндөр хамааралтай, бүтээмж бага, тээвэрлэлт болоод нийлүүлэлтийн сүлжээ сул хөгжсөн. Гэсэн хэдий ч нийгэмд чухал нөлөөтэй салбар тул төрийн зохицуулалт, дэмжлэг их шаарддаг аж. ХАА-н салбар 2000 онд эдийн засгийн 27%-ийг бүрдүүлж байсан бол 2024 онд 7% хүртэл буурсан нь тус салбарын нэмүү өртөг багатай байгааг харуулж буй.

Үндэсний аюулгүй байдал талаас хүнсний хэрэгцээгээ дотооддоо хангах, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх, түүхий эдийг бүтээгдэхүүн болгоход дэмжлэг үзүүлэхэд ХАА-н татаас чиглэгддэг.

### Цар тахал, 2024 оны хүндхэн зудын нөлөөгөөр ХАА-н салбарын татаас сүүлийн жилүүдэд огцом нэмэгдэв:

- Тухайлбал 2020–2024 онд нийт ₮836 тэрбумын татаас олгосон нь 2015–2019 оны нийт татааснаас 4.6 дахин өндөр дүн ажээ. Татаас дээрх хэмжээнд огцом өссөн ч бодит үйлдвэрлэл болоод бүтээмж буурсаар байгаа юм. Татаас огцом өссөн сүүлийн 5 жилд ХАА-н бүтээмж дунджаар -1.9%-аар буурав.



“ХАА-н салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал”-д татаасны дийлэнх хувь нь зарцуулагдаж буй ч бодит үйлдвэрлэл буурсаар байгаа нь **татаас зорилгодоо хүрэхгүй байгааг илтгэнэ.**

### 1. ХАА-н татаас зорилтот бүлэг, малчин өрх, үйлдвэрлэгчдэд хүрч чадаж байна уу?


2024 оны Үндэсний аудитын газрын тайланд “Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал” арга хэмжээнд **₮206 тэрбумын зээлийн** хүүгийн хөнгөлөлтийн татаасыг **буруу төлөвлөн**, олгосон гэжээ.

### 2. Үйлдвэрлэлийг дэмжих нэр дор татаасыг улс төрийн зорилгоор ашиглаж байж болзошгүй.

2015 оноос хойш ХАА-н салбарын татаас дунджаар 70%-аар өссөн бөгөөд **сонгуулийн жилүүдэд дунджаар 250% өсжээ.** 2020, 2024 онуудад давагдашгүй хүчин зүйлс тохиолдсон хэдий ч тус үйл явдлаар дамжуулан орон нутагт өөр зорилгоор өндөр хэмжээний хөрөнгө зарцуулдаг байх боломжтой харагдана.

### 3. Хэтийдсэн татаас, урамшуулал ХАА-н салбар зах зээлийн зарчмаар ажиллахад саад учруулж байна уу?


ХАА-н салбарын ДНБ-д эзлэх татаасны хэмжээ сүүлийн 5 жилд 2.9%-д хүрч, 2015–2019 оны дунджаас 1.7 нэгж хувиар өссөн нь тус салбарын татааснаас хараат байдал нэмэгдэж буй дохио мөн юм.



### 3. Эрчим хүчний салбар дахь татаас

#### Татаас огцом өссөн боловч эрчим хүчний компаниудын алдагдал үүнээс ч илүү хэвээр

Тэрбум ₮



Эх сурвалж: УСХ; СЯ; УАГ; ЭХЗХ

Тайлбар: Компаниудын өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос тооцсон алдагдлыг харуулав.

#### Ирэх таван жилд багадаа ₮1.3 их наядын алдагдлыг нөхөх шаардлагатай болно

2020–2023 оны хооронд дунджаар ₮46 тэрбум эрчим хүчний татаас олгосон бол цахилгааны үнийг нэмэгдүүлэн, шинэчлэн тогтоосон 2024 онд ₮222 тэрбум татаасыг олгожээ. Хэдийгээр 2024 онд цахилгааны үнийг шинэчлэн тогтоон эрчим хүчний компаниудын орлого 10%-аар нэмэгдсэн ч эсрэг талд алдагдал өмнөх оноос 136%-аар нэмэгдэж, татаас огцом өсөх болсон нь анхаарал татахуйц байна.

Ерөнхий тооцооллоор тус салбарын компаниудын алдагдал нь орлогын 8.5%-тай тэнцэж байгаа бөгөөд цаашид 2024 оноос суурь үнийг хөдөлгөхгүй, цахилгааны хэрэглээ 6%-аар тогтмол өсөх тохиолдолд 2030 он хүртэл ₮1.3 их наядын алдагдлыг хагас их наядас илүү татаасаар нөхөх ажээ. Гэвч тус өндөр дүн нь цахилгааны нийлүүлэлт, эх үүсвэрийг нэмэгдүүлэхгүй гэдгийг санах хэрэгтэй.

Эрчим хүчний салбар нь үндэсний аюулгүй байдлын тулгуур, хөгжлийн суурь багана юм. Гэхдээ Монголд эрчим хүчний компаниудын алдагдал өндөр, дулааны станцуудын өр төлбөр өссөөр буй, төсвөөс их татаас авдаг ч хүрэлцдэггүй гээд олон асуудалтай.

Тухайлбал төвийн бүсийн чухал эх үүсвэр болох Дулааны III цахилгаан станцын зуухнуудын хамгийн “он залуу” нь ирэх жил 45 нас хүрэх нь. Иймдээ ч хөгшин зуухнууд дэлбэрэх, турбинууд задрах ослууд ойр ойрхон дуулдах болсон нь тус салбарт хөрөнгө оруулалт хэрэгтэй байгаа дохио мөн.

2020 оноос хойш Монголын цахилгааны хэрэглээ жилд дунджаар 6%-аар тогтмол өсөж, дунджаар ₮66 тэрбумын балансын алдагдалтай ажиллажээ.

Цахилгааны нийлүүлэлт хязгаарлагдмал, үнийг тогтмол шинэчлэн тогтоодоггүй нь алдагдлыг нэмэгдүүлж, татаасны хэмжээ өсөх нэгэн шалтгаан болсон. Улмаар 2020 оноос хойш эрчим хүч, дулааны татаас жилд дунджаар 58%-аар нэмэгдэв.



**Тэргүүн асуудал:** Хамгийн чухал хэрэгцээтэй байгаа шинэчлэл, нийлүүлэлтийн доголдлыг татаас шийдэж чадах уу?

#### Татаас жил бүр өсөж буй хэдий ч алдагдлаа ч нөхөж хүрэлцэхгүйн дээр компаниудын өр төлбөр ч улам нэмэгдэх магадлалтай:


- 2020 оноос хойш дулааны станцуудын нүүрсний уурхайд төлөх өр ойролцоогоор ₮4 тэрбумаар нэмэгдэж буй нь алдагдлаа нөхөж чадахгүй, өр төлбөр үүссээр буйг харуулах аж.

#### Үнийг алдагдалтай тогтоож, татаасаар санхүүжүүлсээр байгаа нь өгөөжөө давсан сөрөг нөлөөтэй юм биш биз?

- Төвийн бүсийн нэгдсэн сүлжээ нэгж кВт цахилгааныг 10.8%-ийн алдагдалтай, баруун бүсийн нэгдсэн сүлжээ 46%-ийн алдагдалтай үнээр борлуулж байна. Гэхдээ үнийг алдагдалтай тогтоодгоос гадна эрчим хүчний салбарын өрсөлдөөнгүй, инновацгүй байдал нь нэгж цахилгаан үйлдвэрлэх өртгийг өндөр байлгаж байж ч болзошгүй юм.

## 4. Нийтийн тээврийн салбар дахь татаас

Нийслэлийн нийтийн тээврийн зардлын 10 төгрөг тутмын 9-ийг төсвөөс санхүүжүүлж буй



Эх сурвалж: Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газрын шилэн данс; Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газрын шилэн дансны мэдээллээр 2024 онд нийтийн тээврийн нийт зардал ₮322 тэрбумд хүрсэн бөгөөд үүний ₮289 тэрбум буюу 90%-ийг төсвөөс олгосон татаасаар санхүүжүүлсэн аж.

2024 онд жолоочдын цалинг \$1,000 хүргэх бодлого хэрэгжүүлсэн нь салбарын зардлыг нэмэгдүүлсэн. Нэгэнт өөрсдийн олсон мөнгөөр бус татаасаар зардлаа санхүүжүүлж буй учир зардлыг эдийн засгийн тооцоололгүй, хэнэггүй байдлаар зарцуулах байдал хэвшил болж байж болзошгүй юм.

### Татаасны хэмжээ хурдацтай өссөөр

- Татаасны дүн 2024 онд ₮289 тэрбум хүрсэн нь ердөө жилийн өмнөхөөс ₮123 тэрбум буюу 74%-аар өсжээ. Харин 2025 оны эхний хагаст нийтийн тээврийн алдагдалд ₮179 тэрбумыг олгосон нь 2 жилийн өмнөх бүтэн жилийн дүнгээс ₮12 тэрбумаар өндөр дүн боллоо.

Ийнхүү нийтийн тээврийн алдагдалд олгох татаас 2020 оноос жил тутам 26%-аар өссөөр нийлбэр дүнгээр **₮1.0 их наядад** хүрэв.

### 2025 онд үйл ажиллагааны орлого нэмэгдсэн гэх боловч татаас улам нэмэгдсэн нь зардлын тэлэлт маш өндөр байгааг илтгэв

- 2025 оны 7 сарын байдлаар нийслэлийн нийтийн тээврийн орлого өмнөх оноос 68%-аар нэмэгджээ. Орлого нэмэгдсэн ч тус салбарт олгож буй татаас буурахгүй байгаа нь нөхөн олговор хэлбэрээр олгодог татаас **яг бодит алдагдлыг санхүүжүүлж байна уу** гэх эргэлзээг төрүүлэхүйц юм.

### Хамгийн өндөр татаас авдаг компаниуд дунд төрийн өмчит компани олон аж


- Шилэн дансны мэдээллээр нийслэлийн хэмжээнд 2025 онд 18 төрийн болон хувийн өмчийн байгууллагуудад татаас олгожээ.
  - Шилэн дансны мэдээлэлд тус компаниудад хэдэн төгрөгийн татаас олгосон нь нээлттэй байгаа хэдий ч хэдэн зорчигч зорчсон эсвэл ямар зардал дээр үндэслэн олгодог нь ил тод бус байгааг анхаарах нь зүйтэй.

### Хамгийн өндөр дүнтэй татаас авч буй компаниуд

### Өмчийн хэлбэр

ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ХОЁР ОНӨААТҮГ	Төрийн өмчийн
ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ТАВ	Төрийн өмчийн
ЗОРЧИГЧ ТЭЭВЭР НЭГ ОНӨААТҮГ	Төрийн өмчийн
ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ ОНӨААТҮГ	Төрийн өмчийн
ЭРДЭМТРАНС	Хувийн хэвшил

Эх сурвалж: Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газрын шилэн данс  
Тайлбар: 2025 оны 11 сарын мэдээлэлд үндэслэв. ОНӨААТҮГ- Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



## 5. Анхаарах асуудлууд ба бодлогын зөвлөмж

Татаасны бодлогын зорилго нь чухал бараа, үйлчилгээг нийгэмд хүртээмжтэй болгох, үйлдвэрлэлийг дэмжих, тэгш бус байдлыг бууруулахын тулд эмзэг бүлэгт чиглэсэн дэмжлэг үзүүлэхэд оршино.

Татаас нь мөн зах зээлийн гажуудлыг бууруулах, шинэ салбарыг дэмжих, барааны үнийг бага байлгахад чиглэдэг. Гэвч Монголын хувьд эдгээр зорилгод хүрч буй эсэхийг хэмжих судалгаа, тайлан, дүгнэлт тун дутагдалтай байна.

### Асуудлын хураангуй:

#### 1. Хөдөө аж ахуйн салбар

- Хөдөлмөр их шингээдэг ч бүтээмж маш багатай, татаас тус салбарын бүтээмжийг дэмждэггүй;
- Бусад салбартай харьцуулахад улс төрийн популист амлалтаар татаас өсгөдөг байх өндөр магадлалтай;
- Татаас зах зээлийн зарчмаар ажиллах, өрсөлдөх чадварыг бууруулдаг байх эрсдэлтэй;
- Татаас зорилтот бүлэгт бүтэн хүрч буй эсэх эргэлзээтэй.

#### 2. Эрчим хүчний салбар

- Үйлдвэр, тоног төхөөрөмжийн насжилт өндөр;
- Үнийг хүчээр барьдгаас шалтгаалан эрчим хүчний станцууд алдагдалтай ажилладаг тул тоног, төхөөрөмж шинэчлэх санхүүгийн боломж сул;
- Салбарын инновац бага, хэт уламжлалт тогтолцоотой;
- Салбарын асуудлыг дан ганц татаасаар шийдэх боломжгүй.

#### 3. Нийтийн тээврийн салбар

- Татаас зорилгоо биелүүлдэггүй буюу татаас нэмэгдсэн ч чанар, хүртээмж нэмэгддэггүй;
- Татаас салбарын шинэ хөрөнгө оруулалтыг үргээдэг байх магадлалтай;
- Компаниудын зардлын бодит тооцоо, түүнд үндэслэн олгож буй нөхөн олговор (татаас)-ын тайлан мэдээлэл байдаггүй;
- Төр өөрөө үйлчилгээ үзүүлж, өөр өөртөө хяналтгүй, өндөр татаас олгодог.

### Бодлогын зөвлөмж:

#### 1. Ил тод байдлыг хангах

Шилэн данс болон аудитын тайланд татаас олгосон дүнг дурдсан хэдий ч тэрхүү татаас ямар сувгаар олгогдож байгаа нь тодорхойгүй.

- Төрийн захиргааны, холбогдох чиг үүргийн байгууллагууд татаасны бодит дүнг **тогтмол мэдээлдэг** байх;
- Салбаруудад олгож буй татаасны нийт дүнг зөвхөн мэдээлэх бус **ямар үзүүлэлтэд үндэслэн** олгосныг ил тод мэдээлэх;

Улмаар, мэдээлэл ил тод байснаар хяналт тавих, үр дүнг шинжлэх боломж бүрдэнэ.

#### 2. Үр дүнг шинжлэх, тайлагнах

Дүгнэлт, тайлан, хяналт дутагдалтай байх нь татаасны өртгийг үнэгүйдүүлж, төсвийн дарамтыг нэмэгдүүлж, татаасыг улс төрийн хэрэгсэл болгож ашиглах боломжийг олгох эрсдэлтэй.

- Татаас авдаг байгууллагууд төсвөөс санхүүжилт авч буй тул өөрсдийн орлого, зарлагын тайланг нийтэлж, хяналт тавих боломжоор хангах ёстой;
- Татаас өсөж, буурч буйг бус **зорилтдоо хүрсэн үү, үр дүн гарсан уу** гэдгийг үнэлж, дүгнэдэг, тайлагнадаг болох шаардлагатай байна.

#### 3. Зохистой хэмжээгээр олгох

Зохистой татаасны хэмжээг тодорхойлж, эдийн засгийн тооцоолол хийхгүйгээр татаасыг хэт өсгөх нь зах зээлийн гажуудлыг бий болгож, татааснаас хараат салбаруудын бүтцийн шинэчлэлийг удаашруулж, шинэ хөрөнгө оруулалтаас зайлсхийх сэдэл болж байна. Иймд:

- Аливаа татаасыг олгохдоо эдийн засгийн тооцоололтой, эерэг, сөрөг нөлөөг тооцож чаддаг болох шаардлагатай.



## 6. Хэрэгтэй холбоосууд

Тайлан, Танилцуулгууд:

Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газар, 2024. Шилэн дансны мэдээлэл:

<https://shilendans.gov.mn/organization/28788?ry=2025&group=117&year=2025&month=11&type=3&rfor=29625&rf=1116&rm=11>

Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр, 2025. Эмзэг бүлгийн өрхийн цэвэр эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлэх нь:

[https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/2025-09/empowering\\_vulnerable\\_households\\_to\\_access\\_affordable\\_and\\_clean\\_energy\\_final\\_mng.pdf](https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/2025-09/empowering_vulnerable_households_to_access_affordable_and_clean_energy_final_mng.pdf)

Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ), 2023. Хөдөө аж ахуйн дэмжлэг, урамшууллын судалгааны тайлан:

<https://url-shortener.me/4CB7>

Сангийн яам, 2025. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга:

<https://mof.gov.mn/files/uploads/->

[%D0%B8%D0%B9%D0%BD\\_%D1%82%D0%B0%D0%BD%D0%B8%D0%BB%D1%86%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0-2024.pdf](https://mof.gov.mn/files/uploads/-%D0%B8%D0%B9%D0%BD_%D1%82%D0%B0%D0%BD%D0%B8%D0%BB%D1%86%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0-2024.pdf)

Үндэсний аудитын газар, 2025. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан:

<https://d.parliament.mn/tusul/2c3bb4ef-1bc2-442a-bc40-aad4a63515ab>

Эдийн засаг, хөгжлийн яам, 2024. Макро эдийн засгийн танилцуулга:

<https://med.gov.mn/uploads/users/3962/files/M24Q4MN.pdf>

Статистик:

Зам, тээврийн яам, 2025. Зам, тээврийн салбарын 2024 оны жилийн эцсийн статистикийн эмхэтгэл:


<https://mrt.gov.mn/i/4401>

Эрчим хүчний зохицуулах хороо, 2024. Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд:

<https://online.fliphtml5.com/seigx/bmpe/#p=10>

Үндэсний статистикийн хороо:

<https://www.1212.mn/mn>





Тинк Монгол Институт нь бие даасан судалгаа, санал санаачилгаар Монголын эдийн засгийн бодлогыг сайжруулах зорилготой эдийн засгийн бодлогын судалгааны ашгийн бус ИНСТИТУТ ЮМ.

**Тинк Монгол нь дараах чухал гурван бодлогын асуудлыг үндсэн чиглэлээ болгоно:**

Нөөцийн эдийн засаг  
& Засаглал

Төсөв & Мөнгөний  
бодлого

Бизнесийн орчин &  
Өрсөлдөх чадвар

Бидний эрхэм зорилго нь судалгааг бодлогын мэтгэлцээнээс эхлээд манлайллын хөтөлбөр, подкаст, цахим платформ зэрэг бодит үйл ажиллагаатай уялдуулж олон талт арга замаар Монголын хөгжлийн шинэ үеийг дэмжиж тодорхойлно.

## 7. Санамж

Энэхүү бодлогын тоймд дурдагдах аливаа санал, бодлогын зөвлөмж, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Тинк Монгол Институт, түүний ажилтнууд, тоймд дурдагдсан байгууллагуудын албан ёсны байр суурийг заавал илэрхийлэхгүй бөгөөд 2025 оны 12-р сарын байдлаар олон нийтэд ил болсон мэдээлэлд үндэслэгдсэн болно. Энэхүү тоймд дурдагдсан тодорхой бодлого, засгийн газар, байгууллага, эсвэл бусад субъектүүд нь тухайн судлаач болон Тинк Монгол Институтээс тэдгээрийг дэмжиж, баталж, эсвэл эсэргүүцэж байгаа гэсэн утгыг агуулаагүй болно. Судлаач болон Тинк Монгол Институт нь энд агуулагдсан мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдал, цаг хугацааны хувьд аливаа баталгааг өгөхгүй бөгөөд дурдагдсан мэдээллийг ашигласнаас үүдэн гарах алдаа, орхигдол, үр дагаварт хариуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Бүх мэдээлэл, эшлэлүүд нь олон нийтэд ил болсон, найдвартай гэж үзэж болох эх сурвалжаас авсан боловч тэдгээрийн үнэн зөв, бүрэн бүтэн байдалд баталгаа өгөх боломжгүй. Энэхүү тойм нь зөвхөн мэдээллийн болон академик зорилгоор боловсруулагдсан бөгөөд санхүүгийн, хууль эрхзүйн заавар гэж ойлгож болохгүй. Уншигчид энэхүү мэдээллийг эх сурвалжтай тулган шалгаж, өөрийн дүгнэлт, шийдвэр гаргахыг зөвлөж байна. Судлаач болон Тинк Монгол Институт нь энэхүү баримт бичгийг хэрэглэснээс эсвэл түүний агуулгад тулгуурласнаас үүдэн гарсан шууд, шууд бус, санамсаргүй, эсвэл үр дагавартай аливаа хохиролд хариуцлага хүлээхгүй.

Энэхүү бодлогын тоймыг Тинк Монгол Институт боловсруулсан болно. Тоймын аливаа хэсгийг Тинк Монгол Институтээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр хуулбарлах, тараах, нийтлэх, эсвэл өөр ямар нэгэн байдлаар ашиглахыг хатуу хориглоно. Зөвхөн тойм, шүүмж, нийтлэлд зориулж товч эшлэл ашиглахдаа зохих ёсоор эшлэл оруулсан тохиолдолд зөвшөөрөгдөнө.

Тинк Монгол Институт (Тинк Монгол) нь бие даасан судалгаа, санал санаачилгаар Монголын эдийн засгийн бодлогыг сайжруулах зорилготой нам бус, ашгийн бус эдийн засгийн бодлогын судалгааны институт юм. Тус институтийн гол судалгааны чиглэлүүд нь “Байгалийн нөөцийн эдийн засаг, засаглал,” “Төсөв, мөнгөний бодлого,” “Бизнесийн орчин ба өрсөлдөх чадвар” бөгөөд Тинк Монгол нь бодит ач холбогдол бүхий үзэл бодол, санаачилгын талбар болж, үр дүнд чиглэсэн судалгааг дэмжиж, Монголын ардчилал, эдийн засаг, нийгмийн ирээдүйг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулна.

Бидэнтэй холбогдох:

Facebook – [Тинк Монгол /Think Mongol/](#)

LinkedIn – [Think Mongol Institute](#)

Email: [contact@thinkmongol.mn](mailto:contact@thinkmongol.mn)

